

ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ЗАРИМ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ /Манай улсын нөхцөлд/

Илтгэгч: С.Баярхүү /MBA, CPA/
ХААИС-ЭЗБС-Бүртгэл, санхүүгийн тэнхимийн багш

Зөвлөгч: Г.Алтанзаяа /PhD, Prof/
ТИНЗ нийгэмлэгийн гүйцэтгэх захирал
МУИС-ХС-Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн эрхлэгч


“Татварын орчны шинэтгэл” онол практикийн бага хуралд
2012 оны 12-р сарын 5

Зорилтот асуудлууд:

- 3 тэрбум ₮-өөс илүү татвар ногдуулах орлого тайлагнасан /эсвэл тайлагнадаг/ компаниудын хувьд:
 1. Ямар хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцох вэ?
 2. Дундаж татварын түвшинг ашиглаж хойшлогдсон татварыг хэрхэн тооцох вэ?
 3. Манай нөхцөлд хойшлогдсон татварын тооцооллыг хэрхэн хялбарчилж болох вэ?

Асуудал 1:

3 тэрбум ₮-с илүү татвар ногдуулах
орлого тайлагнасан бол ямар хувь
хэмжээгээр хойшлогдсон татварыг
Тооцох вэ?



Манай практикийн алдаа:

	Тохиолдол 1:	Тохиолдол 2:	Зөрүү
Татварын өмнөх ашиг	2,999,999,700	3,000,000,001	(301)
Байнгын зөрүү	(350,000,000)	(350,000,000)	-
Татвар ногдох түр зөрүү	(97,000,000)	(97,000,000)	-
Хасагдах түр зөрүү	447,000,300	447,000,300	-
Татвар ногдуулах орлого	3,000,000,000	3,000,000,301	(301)
Тайлант үеийн орлогын татварын зардал	300,000,000	300,000,075	(75)
Татварын түвшин	10%	25%	(15%)
Хойшлогдсон татварын өр	9,700,000	24,250,000	(14,550,000)
Хойшлогдсон татварын хөрөнгө	44,700,030	111,750,075	(67,050,045)
Хойшлогдсон татварын зардал (хэмнэлт)	(35,000,030)	(87,500,075)	52,500,045
Орлогын татварын зардал	264,999,970	212,500,000	52,499,970
Татвар ногдуулах орлогын 1 төгрөгт ногдох хэлбэлзэл			(174,419)

Орлогын дундаж татварын ТҮВШИН

- **Ахиуц татварын түвшин /Marginal tax rate/** нь татварын ногдуулах орлогын нэмэлт 1 төгрөг тутамд ногдуулах татварын түвшин юм.
- МУ-ын ААНОАТ-ын тухай хуулиарх орлогын татварын шатлал ба ахиуц татварын түвшин:

Татвар ногдуулах орлого	Ахиуц татварын түвшин
0₮ - 3,000,000,000₮	10%
3,000,000,001₮ - түүнээс дээш	25%

ААНОАТ-ын тухай хуулиар Ахиуц татварын түвшин

Орлогын татварын түвшин

Ахиуц татварын түвшин


25%

10%


1

3,000,000,001

Татвар ногдуулах орлого



- **Дундаж татварын түвшин /Average tax rate/** бол татвар ногдуулах орлогын нэг төгрөг тутамд ногдох татварын хэмжээ юм. Үүнийг бас **үр ашигт татварын түвшин /effective tax rate/** гэж



- ААНОАТ-ын тухай хуулиар бол ахиуц татварын түвшний хамгийн бага хэмжээ нь 10%, хамгийн их түвшин 25% учраас дундаж татварын түвшин 10%-тай тэнцүү юмуу их ба 25%-иас бага байх ёстой.
- Ерөнхий тохиолдолд

$10\% \leq$ Дундаж татварын түвшин $< 25\%$

Тохиолдол	Дундаж татварын түвшин
Татвар ногдуулах орлого ≤ 3 тэрбум төгрөг	10%
Татвар ногдуулах орлого > 3 тэрбум төгрөг	10% > ба < 25%

Дундаж татварын түвшинг тооцох:
/MUSC компанийн үйл
ажиллагааны тайлант 1-р жил/

- MUSC компани үйл ажиллагааны тайлант 1-р жилд 2.8 тэрбум ₮-н татварын өмнөх ашиг тайлагнасан ба хасагдах зардал болохгүй байнгын зөрүү 140 сая ₮, татвар ногдох түр зөрүү 120 сая ₮, хасагдах түр зөрүү 270 сая ₮ үүсчээ.

1-р тайлант жилийн ногдуулах татвар болон дундаж татварын түвшинг тооцвол:

		Тайлант жил	
		!	
Татварын өмнөх ашиг			2,800,000,000
Байнгын зөрүү			140,000,000
Түр зөрүүний цэвэр өөрчлөлт:			
(-)	Татвар ногдох	120,000,000	
(+)	Хасагдах	270,000,000	150,000,000
Татвар ногдуулах орлого:			3,090,000,000
	10%-н татвар ногдох хэсэг	3,000,000,000	
	25%-н татвар ногдох хэсэг	90,000,000	3,090,000,000
Тайлант үеийн орлогын татвар			322,500,000
Дундаж татварын түвшин			10.44%*

* *Ногдуулсан татвар/Татвар ногдуулах орлого = =*
 $322,500,000 / 3,090,000,000 = 0.1044$

Асуудал 2:

Дундаж татварын түвшинг ашиглаж хойшлогдсон татварыг хэрхэн тооцох вэ?

- **MUSC компанийн жишээ ... үргэлжлэл**
- MUSC компани 1 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа. Тус компанийн удирдлага үйл ажиллагаагаа дор хаяж ирэх 4 жилээр төлөвлөж, төсөвлөсөн тайлангуудыг жил бүрийн эцэст бэлтгэж бодлого, шийдвэр гаргалтандаа ашигладаг.
- Мөн тус компани жил бүр 3 тэрбум ₮-өөс илүү хэмжээний татварын өмнөх ашигтай ажиллана гэж үзэж байгаа ба мөн санхүүгийн болон татварын тайлагналын зорилгоорх хүлээн зөвшөөрөх орлого, зардлын зүйлүүдийн дүн нилээд зөрүүтэй байна гэж төсөөлж байгаа.
- Жил бүр байнгын ба түр зөрүү үүсдэг, тэдгээр үүссэн түр зөрүү нь дараалсан 3 жилийн хугацаанд тэнцүү дүнгээр буцаагддаг гээд тооцооллыг хялбарчилж авч үзье.

Тайлант 1-р жилд үүссэн гүйцэтгэлээрх зөрүү ба 2-5-р жилүүдэд үүсэх ба буцаагдах тооцоолсон зөрүү

Зөрүүний үүсэлт ба буцаалт	Тайлант жил	II-V жилүүдийн төсөөлөл				
	I	II	III	IV	V	
Байнгын зөрүү	140,000,000	180,000,000	80,000,000	(170,000,000)	120,000,000	
<u>Түр зөрүүний үүсэлт:</u>						
Татвар ногдох түр зөрүү	120,000,000	240,000,000	180,000,000	150,000,000	210,000,000	
Хасагдах түр зөрүү	270,000,000	330,000,000	120,000,000	180,000,000	120,000,000	
<u>Түр зөрүүний буцаалт:</u>						
Татвар ногдох түр зөрүүний буцаагдах хэсэг:						
I жилийнхээс	-	40,000,000	40,000,000	40,000,000	-	
II жилийнхээс	-	-	80,000,000	80,000,000	80,000,000	
III жилийнхээс	-	-	-	60,000,000	60,000,000	
IV жилийнхээс	-	-	-	-	<u>50,000,000</u>	
Татвар ногдох түр зөрүүний буцаагдах нийт дүн	-	40,000,000	120,000,000	180,000,000	190,000,000	
Хасагдах түр зөрүүний буцаагдах хэсэг:						
I жилийнхээс	-	90,000,000	90,000,000	90,000,000	-	
II жилийнхээс	-	-	110,000,000	110,000,000	110,000,000	
III жилийнхээс	-	-	-	40,000,000	40,000,000	
IV жилийнхээс	-	-	-	-	<u>60,000,000</u>	
Хасагдах түр зөрүүний буцаагдах нийт дүн	-	90,000,000	200,000,000	240,000,000	210,000,000	

2-5-р жилүүдийн тооцоологдсон түр зөрүү, татварын өмнөх ашиг, татвар ногдуулах орлого ба дундаж татварын түвшин

	II-V жилүүдийн төсөөлөл			
	II	III	IV	V
<u>Хуримтлагдсан түр зөрүү /жилийн эхэнд/:</u>				
Татвар ногдох	120,000,000	320,000,000	380,000,000	350,000,000
Хасагдах	270,000,000	510,000,000	430,000,000	370,000,000
<u>Түр зөрүүний үүсэлт:</u>				
Татвар ногдох	240,000,000	180,000,000	150,000,000	210,000,000
Хасагдах	330,000,000	120,000,000	180,000,000	120,000,000
<u>Түр зөрүүний буцаалт:</u>				
Татвар ногдох	40,000,000	120,000,000	180,000,000	190,000,000
Хасагдах	90,000,000	200,000,000	240,000,000	210,000,000
<u>Түр зөрүүний цэвэр өөрчлөлт:</u>				
Татвар ногдох	200,000,000	60,000,000	(30,000,000)	20,000,000
Хасагдах	240,000,000	(80,000,000)	(60,000,000)	(90,000,000)
<u>Хуримтлагдсан түр зөрүү /жилийн эцэст/:</u>				
Татвар ногдох	320,000,000	380,000,000	350,000,000	370,000,000
Хасагдах	510,000,000	430,000,000	370,000,000	280,000,000
Тооцоолсон татварын өмнөх ашиг	2,970,000,000	3,400,000,000	4,200,000,000	5,800,000,000
Байнгын зөрүү	180,000,000	80,000,000	(170,000,000)	120,000,000
Тооцоолсон татвар ногдуулах орлого	3,190,000,000	3,340,000,000	4,000,000,000	5,810,000,000
10%-н татвар ногдох хэсэг	3,000,000,000	3,000,000,000	3,000,000,000	3,000,000,000
25%-н татвар ногдох хэсэг	190,000,000	340,000,000	1,000,000,000	2,810,000,000
Нийт тооцоолсон орлогын татвар	347,500,000	385,000,000	550,000,000	1,002,500,000
Тооцоолсон дундаж татвар	10.89%	11.53%	13.75%	17.25%

- Тайлант 1-р жилийн эцэс дэх хойшлогдсон татварын өр дансны үлдэгдэл:

Буцаагдах жилүүд	I жилийн эцэс дэх хуримтлагдсан татвар ногдох түр зөрүү	Тооцоолсон үр ашигт татварын түвшин	Хойшлогдсон татварын өр
II	40,000,000	10.89%	4,357,367
III	40,000,000	11.53%	4,610,778
IV	40,000,000	13.75%	5,500,000
V	=	17.25%	=
Нийт дүн	120,000,000		14,468,145

- Тайлант 1-р жилийн эцэс дэх хойшлогдсон татварын хөрөнгө дансны үлдэгдэл:

Буцаагдах жилүүд	I жилийн эцэс дэх хуримтлагдсан хасагдах түр зөрүү	Тооцоолсон үр ашигт татварын түвшин	Хойшлогдсон татварын хөрөнгө
II	90,000,000	10.89%	9,804,075
III	90,000,000	11.53%	10,374,251
IV	90,000,000	13.75%	12,375,000
V	-	17.25%	-
Нийт дүн	270,000,000		32,553,327

- Тайлант 1-р жилийн орлогын татварын зардал:

		Тайлант жил
		I
Тайлант үеийн орлогын татвар/өр		322,500,000
Хойшлогдсон татварын өр с2	14,468,145	
Хойшлогдсон татварын өр с1	-	
Хойшлогдсон татварын өрийн өсөлт (бууралт)	14,468,145	
Хойшлогдсон татварын хөрөнгө с2	32,553,327	
Хойшлогдсон татварын хөрөнгө с1	-	
Хойшлогдсон татварын хөрөнгийн өсөлт (бууралт)	32,553,327	
Хойшлогдсон татварын зардал (хэмнэлт)		(18,085,182)
Орлогын татварын зардал		304,414,818

- Тайлант 1-р жилийн орлогын татварын журналын бичилт:

дт	Орлогын татварын зардал	304,414,818	
дт	Хойшлогдсон татварын хөрөнгө	32,553,327	
	кт	Хойшлогдсон татварын өр	14,468,145
	кт	Тайлант үеийн орлогын татвар/өр	322,500,000

MUSC компанийн үйл ажиллагааны

2-р жилд:

- Тус компанийн тайлант 2-р жилд үүссэн гүйцэтгэлээрх татвар ногдох түр зөрүү 270 сая ₮ буюу 1-р жилийн эцэст төлөвлөж байснаас 30 сая ₮-р илүү, хасагдах түр зөрүү 420 сая ₮ буюу 1-р жилийн эцэст төлөвлөж байснаас 90 сая ₮-р илүү тус тус байна гэж үзье.
- 3-5-р жилүүдэд татварын өмнөх ашиг ба үүсэх зөрүүний хувьд хувьд 1-р жилд төлөвлөж байсан дүнгүүд хэвээрээ байна гэж үзсэн гэе.
- Тус компани үйл ажиллагаагаа ирэх 4 жилээр төлөвлөдөг учир 2-р тайлант жилийн хувьд 6-р жилийн дүнг нэмж төлөвлөсөн.

Тайлант 2-р жилд үүссэн гүйцэтгэлээрх зөрүү ба 3-6-р жилүүдэд үүсэх ба буцаагдах тооцоолсон зөрүү

Зөрүүний үүсэлт ба буцаалт	Тайлант жил	III-VI жилүүдийн төсөөлөл			
	II	III	IV	V	VI
Байнгын зөрүү	180,000,000	80,000,000	(170,000,000)	120,000,000	(200,000,000)
Түр зөрүүний үүсэлт:					
Татвар ногдох түр зөрүү	270,000,000	180,000,000	150,000,000	210,000,000	240,000,000
Хасагдах түр зөрүү	420,000,000	120,000,000	180,000,000	120,000,000	270,000,000
Түр зөрүүний буцаалт:					
Татвар ногдох түр зөрүүний буцаагдах хэсэг:					
I жилийнхээс	40,000,000	40,000,000	40,000,000	-	-
II жилийнхээс	-	90,000,000	90,000,000	90,000,000	-
III жилийнхээс	-	-	60,000,000	60,000,000	60,000,000
IV жилийнхээс	-	-	-	50,000,000	50,000,000
V жилийнхээс	-	-	-	-	<u>70,000,000</u>
Татвар ногдох түр зөрүүний буцаагдах нийт дүн	40,000,000	130,000,000	190,000,000	200,000,000	180,000,000
Хасагдах түр зөрүүний буцаагдах хэсэг:					
I жилийнхээс	90,000,000	90,000,000	90,000,000	-	-
II жилийнхээс	-	140,000,000	140,000,000	140,000,000	-
III жилийнхээс	-	-	40,000,000	40,000,000	40,000,000
IV жилийнхээс	-	-	-	60,000,000	60,000,000
V жилийнхээс	-	-	-	-	<u>40,000,000</u>
Хасагдах түр зөрүүний буцаагдах нийт дүн	90,000,000	230,000,000	270,000,000	240,000,000	140,000,000

- Тайлант 2-р жилийн татварын өмнөх ашиг, татвар ногдуулах орлого ба орлогын татварын дүн:

		Тайлант жил	
		II	
Татварын өмнөх ашиг		2,970,000,000	
Байнгын зөрүү		180,000,000	
Түр зөрүүний цэвэр өөрчлөлт:			
(-)	Татвар ногдох	230,000,000	
(+)	Хасагдах	330,000,000	100,000,000
Татвар ногдуулах орлого:		3,250,000,000	
	10%-н татвар ногдох хэсэг	3,000,000,000	
	25%-н татвар ногдох хэсэг	250,000,000	3,250,000,000
Тайлант татвар/өр	үеийн орлогын	362,500,000	
Дундаж татварын түвшин		11.15%	

- Тайлант 2-р жилийн татварын өмнөх ашиг 1-р жилд төлөвлөж байснаар гарсан гэж авч үзээд тайлант жилийн гүйцэтгэлээрх дундаж татварын түвшинг тооцоход 11.15%.
- 1-р жилийн эцэст төлөвлөснөөр бол 2-р жилийн тооцоолсон дундаж татварын түвшин 10.89%.
- Өөрөөр хэлбэл 1-р жилийн хувьд хойшлогдсон татварыг тооцооллыг 10.89%-р хийсэн гэтэл гүйцэтгэлээрх түвшин 11.15% буюу 0.26%-р илүү гарсан нь хойшлогдсон татварыг дутуу тооцоолсон гэсэн үг юм.

3-6-р жилүүдийн тооцоологдсон түр зөрүү, татварын өмнөх ашиг, татвар ногдуулах орлого ба дундаж татварын түвшин

	III-VI жилүүдийн төсөөлөл			
	III	IV	V	VI
Хуримтлагдсан түр зөрүү /жилийн эхэнд/:				
Татвар ногдох	320,000,000	370,000,000	330,000,000	340,000,000
Хасагдах	510,000,000	400,000,000	310,000,000	190,000,000
Түр зөрүүний үүсэлт:				
Татвар ногдох	180,000,000	150,000,000	210,000,000	240,000,000
Хасагдах	120,000,000	180,000,000	120,000,000	270,000,000
Түр зөрүүний буцаалт:				
Татвар ногдох	130,000,000	190,000,000	200,000,000	180,000,000
Хасагдах	230,000,000	270,000,000	240,000,000	140,000,000
Түр зөрүүний цэвэр өөрчлөлт:				
Татвар ногдох	50,000,000	(40,000,000)	10,000,000	60,000,000
Хасагдах	(110,000,000)	(90,000,000)	(120,000,000)	130,000,000
Хуримтлагдсан түр зөрүү /жилийн эцэст/:				
Татвар ногдох	370,000,000	330,000,000	340,000,000	400,000,000
Хасагдах	400,000,000	310,000,000	190,000,000	320,000,000
Тооцоолсон татварын өмнөх ашиг	3,400,000,000	4,200,000,000	5,800,000,000	6,000,000,000
Байнгын зөрүү	80,000,000	(170,000,000)	120,000,000	(200,000,000)
Тооцоолсон татвар ногдуулах орлого	3,320,000,000	3,980,000,000	5,790,000,000	5,870,000,000
10%-н татвар ногдох хэсэг	3,000,000,000	3,000,000,000	3,000,000,000	3,000,000,000
25%-н татвар ногдох хэсэг	320,000,000	980,000,000	2,790,000,000	2,870,000,000
Нийт тооцоолсон орлогын татвар	380,000,000	545,000,000	997,500,000	1,017,500,000
Тооцоолсон үр ашигт татварын түвшин	11.45%	13.69%	17.23%	17.33%

- Тайлант 2-р жилийн эцэс дэх хойшлогдсон татварын өр дансны үлдэгдэл:

Буцаагдах жилүүд	II жилийн эцэс дэх хуримтлагдсан татвар ногдох түр зөрүү	Тооцоолсон үр ашигт татварын түвшин	Хойшлогдсон татварын өр
III	130,000,000	11.45%	14,879,518
IV	130,000,000	13.69%	17,801,508
V	90,000,000	17.23%	15,505,181
VI	-	17.33%	-
Нийт дүн	350,000,000		48,186,207

- Тайлант 2-р жилийн эцэс дэх хойшлогдсон татварын хөрөнгө дансны үлдэгдэл:

Буцаагдах жилүүд	II жилийн эцэс дэх хуримтлагдсан хасагдах түр зөрүү	Тооцоолсон үр ашигт татварын түвшин	Хойшлогдсон татварын хөрөнгө
III	230,000,000	11.45%	26,325,301
IV	230,000,000	13.69%	31,494,975
V	140,000,000	17.23%	24,119,171
VI	-	17.33%	-
Нийт дүн	600,000,000		81,939,447

- Тайлант 2-р жилийн орлогын татварын зардал:

		Тайлант жил
		II
Тайлант үеийн орлогын татвар/өр		362,500,000
Хойшлогдсон татварын өр с2	48,186,207	
Хойшлогдсон татварын өр с1	14,468,145	
Хойшлогдсон татварын өрийн өсөлт (бууралт)	33,718,062	
Хойшлогдсон татварын хөрөнгө с2	81,939,447	
Хойшлогдсон татварын хөрөнгө с1	32,553,327	
Хойшлогдсон татварын хөрөнгийн өсөлт (бууралт)	49,386,120	
Хойшлогдсон татварын зардал (хэмнэлт)		(15,668,059)
Орлогын татварын зардал		346,831,941

- Тайлант 2-р жилийн орлогын татварын журналын бичилт:

дт	Орлогын татварын зардал	346,831,941	
дт	Хойшлогдсон татварын хөрөнгө	49,386,120	
	кт Хойшлогдсон татварын өр		33,718,062
	кт Тайлант үеийн орлогын татвар/өр		362,500,000

- Дараагийн жилүүдийн тооцооллыг энэ мэтчилэн хийнэ.

Асуудал 3:

Манай нөхцөлд хойшлогдсон татварын тооцооллыг хэрхэн хялбарчилж болох вэ?

- Нягтлан бодогч хамгийн дээд зэргийн хүчин чармайлт, нарийвчилсан тооцоолол хийж санхүүгийн тайлангуудын элементүүдийг /хойшлогдсон татвар/ тайлагнах дүнг тодорхойлох ёстой.
- Энэ нь СТОУС-ын үзэл баримтлалын “хамааралтай ба найдвартай байх” гэсэн санхүүгийн тайлангийн мэдээллийн үндсэн зарчмыг мөрдөж, хэрэгжүүлж байгаа хэрэг юм.

- MUSC компанийн үйл ажиллагааны 1-р жилд:

Ирэх жилүүдийнхээ төсөвлөсөн тайлан тооцоо гаргадаггүй учраас нэг төгрөгний ашиг тутамдаа ямар хэмжээний татвар төлөхөө ойролцоогоор тооцоолж мэдэх боломжгүй.

Компанийн үйл ажиллагааны тайлант 1-р жилд үүссэн хоёр төрлийн түр зөрүүнүүд буцаагдах ирээдүйн жилүүдэд ямар хувь хэмжээгээр орлогын татвар төлөхөө мэдэхгүй байгаа учраас 1-р жилийн дундаж татварын түвшингээр хойшлогдсон татвараа тооцох нь хамгийн оновчтой шийдэл болох юм.

Өөрөөр хэлбэл энэ тайлант жилийн гүйцэтгэлээрх дундаж татвар нь ирээдүйн жилүүдийн дүнтэй ойролцоо түвшинд байна гэж төсөөлөхөөс өөр арга үгүй болно.

- MUSC компанийн 1-р тайлант жилийн эцэс дэх хойшлогдсон татварын өр ба хөрөнгө дансны дүнг тооцвол:

Түр зөрүү	Дүн	Дундаж татвар	Хойшлогдсон татвар
Татвар ногдох	120,000,000	10.44%	12,528,000
Хасагдах	270,000,000	10.44%	28,188,000

Дүгнэлт, санал

- 3 тэрбум ₮-өөс дээш татвар ногдуулах орлого тайлагнадаг ААН-үүдийн хувьд түр зөрүү үүссэн тохиолдолд:
 - Хэрэв ирэх жилүүдийн үйл ажиллагаагаа төлөвлөж төсөвлөсөн тайлан гаргадаг бол тэдгээр жилүүдийн дундаж татварын түвшинг ашиглаж хойшлогдсон татварыг тооцох- Томоохон ААН-үүдийн хувьд боломжтой
 - Хэрэв ирэх жилүүдийн төсөвлөсөн тайлан гаргадаггүй, гаргах боломжгүй бол тухайн тайлант жилийн дундаж татварын түвшинг ашиглаж хойшлогдсон татварыг тооцох- Жижиг дунд ААН-үүдий хувьд боломжтой

Ном зүй:

- Санхүүгийн бүртгэл, Н.Самданжамц, 2012 он
- Intermediate accounting, Spiceland, Sepe, Tomassini, 4th edition, 2008
- IFRS Foundation: Training Material for the *IFRS for SMEs* (version 2010-10), Modul 29-Income tax
- Interpretation and application of International financial reporting standard, Barry J.Epstein, Eva K.Jermakowicz, 2010
- www.iasplus.com
- www.ifrs.org